ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын “Асралт-Үйлс” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорнод аймаг<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................ 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл....................................................................5-9

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....................................................................................10

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..........................................................................10

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.......................................................................... 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.................................................................10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт...................10

3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл................................................................. 11

4. Аудитын тайлан...................................................................................................................11

4.1 Ерөнхий зүйл .................................................................................................................11

4.2 Материаллаг байдал .....................................................................................................12

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт...........................................................12

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...............13

4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн...........................13

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .........................................14

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................................14

5. Аудитын илрүүлэлт ...........................................................................................................14

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..............................................................15


## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НА | Нийцлийн аудит |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.03.16. № 376

танай__________-ны №__________-т

ХЭРЛЭН СУМЫН АСРАЛТ-ҮЙЛС
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА М.ЭНХМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэрлэн сумын “Асралт-үйлс” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад олгодог орон нутгийн нэмэгдлийг ажиллагсдад олгосон, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан зэрэг нийт 87.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

2126050163

**Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **287,774,663.40** | **311,213,486.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 33,183,321.37 | 129,847,402.88 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 33,183,320.36 | 129,847,402.88 |
| **3121** | **Төгрөг** | 33,183,320.36 | 129,847,402.88 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 33,183,320.36 | 129,847,402.88 |
| **33** | **АВЛАГА** | 104,219,514.75 | 11,514,657.40 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 104,219,514.75 | 11,514,657.40 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 150,371,827.28 | 169,851,425.95 |
| **351** | **Түүхий эд материал** | 53,212,588.33 | 75,318,888.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 53,212,588.33 | 75,318,888.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 881,808.00 | 4,712,257.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 96,277,430.95 | 89,820,280.95 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,298,398.00 | 9,671,252.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 86,979,032.95 | 80,149,028.95 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **390,513,669.22** | **349,854,347.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 390,513,669.22 | 349,854,347.79 |
| **392** | **Биет хөрөнгө** | 390,246,784.86 | 349,604,143.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 236,571,479.71 | 236,571,479.71 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (35,485,721.95) | (41,400,008.95) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 58,100,000.00 | 58,100,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (38,080,000.00) | (43,800,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 220,308,728.76 | 198,067,728.76 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (108,836,206.36) | (107,961,914.78) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 87,014,430.00 | 72,651,390.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,345,925.29) | (22,624,531.04) |
| 39301 | Програм хангамж | 645,866.00 | 645,866.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (645,866.00) | (645,866.00) |
| **394** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | 266,884.36 | 250,204.09 |
| 39401 | Биологийн хөрөнгө /ТӨҮГ/ | 366,966.00 | 366,966.00 |
| 39402 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/ | (100,081.64) | (116,761.91) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **678,288,332.62** | **661,067,834.01** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **678,288,332.62** | **661,067,834.01** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 678,288,332.62 | 661,067,834.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 758,500,615.97 | 758,500,615.97 |
| 51101 | Өмч: - төрийн | 758,500,615.97 | 758,500,615.97 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 306,251,241.88 | 289,030,743.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 306,251,241.88 | 306,251,241.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (17,220,498.61) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | (386,463,525.23) | (386,463,525.23) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **678,288,332.62** | **661,067,834.01** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,220,680,984.36** | **1,222,925,156.07** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **97,386,186.85** | **1,222,925,156.07** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 97,386,186.85 | 1,222,925,156.07 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 1,103,130,184.20 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,103,130,184.20 |
| 120009 | Бусад орлого | 97,386,186.85 | 119,794,971.87 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,123,294,797.51** | **-** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,123,294,797.51 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,123,294,797.51 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,129,706,807.56** | **1,239,594,821.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,129,706,807.56** | **1,239,594,821.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙ ЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,129,706,807.56 | 1,239,594,821.34 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 637,208,921.00 | 769,913,585.00 |
| 210101 | Үндсэн цалин | 637,208,921.00 | 769,913,585.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,432,324.09 | 90,436,069.35 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | 90,436,069.35 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,167,453.76 | 16,037,610.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,023,119.76 | 12,566,941.83 |
| 210304 | Байрны түрээс | 4,144,334.00 | 3,470,669.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 277,111,186.31 | 239,962,560.07 |
| 210401 | Бичиг хэрэг | 27,955,650.00 | 27,778,756.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,899,400.00 | 2,300,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 66,896,676.53 | 34,206,278.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 3,212,675.00 | 3,380,266.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 177,146,784.78 | 172,296,560.07 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 410,000.00 | 4,905,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 410,000.00 | 4,905,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 510,542.00 | 355,652.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 163,350.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 108,192.00 | 108,192.00 |
| 210807 | Газрын төлбөр | 150,000.00 | 150,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 89,000.00 | 97,460.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 119,866,380.40 | 117,984,344.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54,803,136.52 | 61,467,955.99 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,930,800.00 | 1,858,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 63,132,443.88 | 54,658,388.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **90,974,176.80** | **(16,669,665.27)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 550,833.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 550,833.33 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (550,833.33) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **90,974,176.80** | **(17,220,498.61)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **981,531,806.63** | **1,088,594,730.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,861,838.18** | **34,414,837.02** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,861,838.18 | 34,414,837.02 |
| 120009 | Бусад орлого | 2,861,838.18 | 34,414,837.02 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **978,669,968.45** | **1,054,179,893.80** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 1,054,179,893.80 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 1,054,179,893.80 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 978,669,968.45 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 978,669,968.45 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,003,054,091.40** | **1,051,232,318.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,003,054,091.40** | **1,051,232,318.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,003,054,091.40** | **1,051,232,318.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 469,332,045.27 | 539,769,855.58 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 469,332,045.27 | 539,769,855.58 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 145,979,082.73 | 170,746,346.02 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 145,979,082.73 | 170,746,346.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 69,740,029.01 | 69,803,920.43 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 69,740,029.01 | 69,803,920.43 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 262,569,142.17 | 202,893,758.21 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 3,212,675.00 | 3,280,894.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 259,356,467.17 | 199,612,864.21 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 55,433,792.22 | 68,018,438.74 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 55,270,442.22 | 67,518,438.74 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/ | 163,350.00 | - |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | - | 500,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(21,522,284.77)** | **37,362,411.84** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **86,366,658.39** | **153,161,673.67** |
| 140003 | Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт | 86,366,658.39 | 153,161,673.67 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **46,515,150.00** | **93,860,004.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **46,515,150.00** | **93,860,004.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 46,515,150.00 | 93,860,004.00 |
| 225105 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/ | 46,515,150.00 | 93,860,004.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **39,851,508.39** | **59,301,669.67** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 18,329,223.62 | 96,664,081.51 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 14,854,097.53 | 33,183,321.37 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 33,183,321.37 | 129,847,402.88 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 758,500,615.97 | 386,463,525.23 | 306,251,241.88 | 678,288,332.62 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 758,500,615.97 | 386,463,525.23 | 306,251,241.88 | 678,288,332.62 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 758,500,615.97 | 386,463,525.23 | 306,251,241.88 | 678,288,332.62 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 758,500,615.97 | 386,463,525.23 | 306,251,241.88 | 678,288,332.62 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | -17,220,498.61 | -17,220,498.61 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 758,500,615.97 | 386,463,525.23 | 289,030,743.27 | 661,067,834.01 |

**2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

| Үзүүлэлт | 2024 оны гүйцэтгэл | Дүн | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Бусад орлого | 97,386.19 | - | 119,794.97 | 119,794.97 | - |
| Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих орлого | 1,123,294.80 | 813,702.40 | 1,103,130.18 | 289,427.78 | 135.6 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГЫН ДҮН** | **1,220,680.98** | **813,702.40** | **1,222,925.16** | **409,222.76** | 150.3 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 637,208.92 | 658,085.60 | 769,913.59 | 111,827.99 | 117.0 |
| АО-оос НД-шимтгэлд төлөх зардал | 78,432.32 | 82,260.10 | 90,436.07 | 8,175.97 | 109.9 |
| Байр ашиглалттай холбоотой зардал | 12,023.12 | 17,082.00 | 12,566.94 | -4,515.06 | 73.6 |
| Хангамж бараа материалын зардал | - | 35,516.00 | 33,459.72 | -2,056.28 | 94.2 |
| Нормативт зардал | 177,146.78 | 13,608.10 | 172,296.56 | 158,688.46 | 1266.1 |
| Томилолт, зочны зардал | 410.0 | 3,000 | 4,905 | 1,905.0 | 163.5 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 258.19 | 4,150.60 | 355.65 | -3,794.95 | 8.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 118,297.69 | - | 69,515.62 | 69,515.62 | - |
| Бусад зардал | 105,929.78 | - | 86,696.11 | 86,696.11 | - |
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **1,129,706.81** | **813,702.40** | **1,240,145.26** | **426,442.86** | 152.4 |
| **НИЙТ АШИГ/АЛДАГДАЛ** | 90,974.18 | - | -17,220.10 | -17,220.10 | - |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 87.3 сая төгрөгийн 10 зөрчил[1] илэрснээс, 0.4 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 71.1 сая төгрөгийн 4 албан шаардлага, 15,7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 87,335.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 73,577.5 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Томилолтын зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлтийг 230.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Эрүүл мэндийн сайдын 2017.01.14-ний өдрийн А/04 тушаалаар баталсан Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 1.2-т “Төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, **бусад холбогдох хууль тогтоомж**, Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт болон энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана”,  Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.2.3-т “хоолны зардал” гэж заасныг зөрчсөн байна.
2. Бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсийг олгохдоо ХХОАТ 206.0 мянган төгрөгийг суутган тооцож шилжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.6-т “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д “суутган төлөгч гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “ үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан хувиар татвар ногдуулж, тус хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т заасны дагуу суутгасан албан татварыг харьяалагдах орон нутгийн төсөвт шилжүүлэх”- гэснийг зөрчсөн байна.

### 5.2 Албан шаардлага

1. Тус эрүүл мэндийн төвийн ажиллагсдад орон нутагт ажилласны нэмэгдэл 67,937.5 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь төрөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж үйлчилгээг үзүүлэх гэрээ байгуулан ажилладаг нөхөрлөлийн ажиллагсад төрийн захиргааны, үйлчилгээний, улс төрийн албан хаагчид хамаарагдахгүй болно. Энэ нь Засгийн газрын 2024.02.28-ны 82 дугаар тогтоолоор баталсан  Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын 2.2-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцох үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохдоо МУ-ын ЗГ-ын тогтоолоор баталсан төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтална", Аймгийн Засаг даргатай 2025.01.23 -ны 01 дүгээр гэрээ байгуулсны 5.1.10-т "Төвийн дарга нь төсөв санхүүгийн холбогдох хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой,зарцуулж, хамт олон иргэдэд нээлттэй мэдээлэх"-гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.
2. Өөрийн байранд боломжит талбай байхад үр ашиггүй зардал гарган түрээсийн байрны төлбөрт 3,200.0 мянган төгрөг гаргасан байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн

захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”- гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3. Тайлант онд батлагдсан төсөв 813,702.4 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,120,145.2 мянган төгрөгийг зарцуулж, 426,442.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийг 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5.-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.9.-т “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”- гэж заасантай нийцэхгүй байна.
4. Асралт-Үйлс Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нь өөрийн нөхөр болох гэрээт ажилтан /жолооч/ Г.Мөнхтүвшинтэй 2025.04.14-ний өдөр Хөдөлмөрийн гэрээ байгуулж түргэн тусламжийн жолоочоор ажиллуулан тайлант онд 33,562,200 төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг олгосон байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “"нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг;”, 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна.”, 4.1-т “Дор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:” гэсний 4.1.5-т “улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т "хамаарал бүхий этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, **гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч**, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;, 11 дүгээр зүйлийн 11.1-т "**Албан тушаалтан албан үүргээ** гүйцэтгэхдээ өөрийн болон **өөртэй нь хамаарал бүхий этгээдийн** хувийн ашиг сонирхлыг хөндсөн **захиргааны шийдвэр гаргах**, **удирдах**, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, **гэрээ байгуулах**, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэл, үр дүнгийн урамшуулалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Үр дүнгийн урамшууллыг олгохдоо дотоод хяналт хийх удирдамжийг 2025.12.15 ны өдөр гаргаж, урьдчилсан хяналт шалгалтыг 2025.12.19 ний өдөр хийсэн, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг 2025.12.26 нд арилгах зөвлөмжийг гаргаж, 2025.12.18 нд үр дүнг тооцон олгох тухай тушаалыг гаргасан байна. Энэ нь ЗГ-ын 2024 оны 12 дугаар

сарын 18-ны өдрийн 214 тогтоолоор баталсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.1-т “байгууллагын албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, үйл ажиллагааны онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг баталж, хэрэгжилтэнд хяналт тавих”, Төсвийн тухай хуулийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”- гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Дотоод хяналт шалгалтыг хийх ажлын удирдамжаар шалгалтыг хийж зөрчлийг арилгасны дараа ажлын үр дүнг тооцож олгох шийдвэрийг гарган ажлын үр дүнд суурилсан урамшуулал олгох.

***2. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого, баримтжуулалттай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Бараа материал, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг баримтжуулж, эд хариуцагч бүрээр бүртгэлийг хөтлөөгүй, ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын чанарыг тодорхойлоогүй, актлах болох хасах бараа материал үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн баримтжуулж тоолоогүй, журналын хөлийн дүнгээр нэгтгэсэн жагсаалтыг хавсаргаж гарын үсэг зурсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70,71,72,73 дугаар зүйлд заасан бараа материал, эд хөрөнгийн тооллогыг бүрэн гүйцэд чанартай хийгээгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх, нотлох баримтыг хавсаргах.

***3. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Төсвөөс зарцуулалт хийхдээ нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, нөхөрлөлийн гишүүдийн шийдвэр байхгүй ажил гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3-т "Удирдах эрх бүхий гишүүд олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна", 5-д " Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Нөхөрлөлийн гишүүдийн шийдвэрээр зарцуулалтыг гаргах, анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

ДОА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ

## “Асралт-Үйлс” өрхийн эрүүл мэндийн төвnау 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Томилолтын зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлтийг 230.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна | 1 | 230.0 | 1 | 230.0 | | | | | | | | |
| Бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсийг олгохдоо ХХОАТ суутган тооцож олгоогүй байна. | 1 | 206.0 | 1 | 206.0 | | | | | | | | |
| Үр дүнгийн урамшууллыг олгохдоо дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгаагүй байхад олгосон | 1 | 15,761.8 | | | | | 1 | 15,761.8 | | | | |
| Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг ажиллагсдад олгосон | 1 | 67,937.5 | | | 1 | 67,937.5 | | | | | | |
| Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай хийгээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Нягтлан бодогчийг ажлын байраар хангаагүй түрээсийн зардал гаргасан байна | 1 | 3,200.0 | | | 1 | 3,200.0 | | | | | | |
| Төсвийг хэтрүүлэн зарцуулсан | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг актлахдаа дахин үнэлгээ хийгээгүй, насжилтыг уртасгах арга хэмжээ авч ажиллаагүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **9** | **87,335.3** | **2** | **406.0** | **3** | **71,137.6** | **4** | **15,761.8** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Асралт-Үйлс Эрүүл мэндийн төвийн | 1 | - | | | 1 | Зөрчлийг арилгах | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| дарга нь өөрийн нөхөр болох гэрээт ажилтан /жолооч/ Г.Мөнхтүвшинтэй 2025.04.14-ний өдөр Хөдөлмөрийн гэрээ байгуулж түргэн тусламжийн жолоочоор ажиллуулан тайлант онд 33,562,200 төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг олгосон байна. | | | | | | тухай | | |
| Дүн | **1** | **-** | | | **1** | | | |